ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

"ХАЙ БРИЖ КРЕДИТ ББСБ" ХХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, "Хай бриж кредит ББСБ" ХХК ("Компани" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Бид Компанийн дараах бүрэлдэхүүн бүхий санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан,
- Тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн

шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Материаллаг байдал: Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 5,881.15 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт орлогын 2.0 хувиар тооцон тогтоосон.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Байгууллагын дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд чухал үүрэгтэй байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл татан буулгахаас өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэнэ. Ийнхүү бэлтгэхдээ Компани үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол түс зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг бүхэлд нь илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг боловч ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, тодруулгууд, бүтэц, агуулгыг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд багтдаг.

УЛААНБААТАР ХОТ
КОНСИСТЕНТ АУДИТ ХХК
9022030464 6725651

Ж.САРАНТУЯА
Гүйцэтгэх захирал, Партнер
Консистент аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол улс
2025 оны 02 сарын 27

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулга	2024.12.31	2023.12.31
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	124,707,580.83	31,747,458.30
Харилцагчдад олгосон зээл	8	2,117,683,069.28	2,344,279,400.57
Бусад авлага	9	147,178,393.57	67,242,047.22
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага		1,332,764.67	-
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		465,465.00	465,465.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		**2,391,367,273.35**	**2,443,734,371.09**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	347,453,362.81	202,746,979.43
Биет бус хөрөнгө	11	2,687,084.48	2,687,084.48
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**350,140,447.29**	**205,434,063.91**
Нийт хөрөнгийн дүн		**2,741,507,720.64**	**2,649,168,435.00**
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбр			
Татварын өглөг		4,657,273.78	4,763,370.46
Цалингийн өглөг		-	4,000.00
Богино хугацаат банкны зээл	12	9,908,511.00	-
Зээлийн хүүгийн өглөг		1,783,206.87	-
Бусад өр төлбөр		-	18,011.58
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**16,348,991.65**	**4,785,382.04**
Урт хугацаат өр төлбөр			
Банк авсан урт хугацаат зээл	12	114,779,326.00	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		**114,779,326.00**	**-**
Өр төлбөрийн нийт дүн		**131,128,317.65**	**4,785,382.04**
Эздийн өмч		-	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	13	2,600,000,000.00	2,600,000,000.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	14	10,379,402.99	44,383,052.96
Эздийн өмчийн дүн		2,610,379,402.99	**2,644,383,052.96**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		**2,741,507,720.64**	**2,649,168,435.00**

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулга	2024.12.31	2023.12.31
Хүүгийн орлого	15	290,611,558.95	283,954,279.65
Хүүний зардал	12	7,441,368.09	-
Хүүгийн цэвэр орлого		**283,170,190.86**	**283,954,279.65**
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого		2,062,509.02	-
Арилжааны цэвэр орлого		1,383,614.29	-
Хүүгийн бус орлогын дүн		**3,446,123.31**	-
Ажилчдын зардал	16	72,232,535.54	64,932,734.26
Үндсэн хөрөнгийн элэгдэл	17	24,188,264.62	20,344,479.43
Бусад зардал		50,934,434.42	44,632,710.99
Хүүгийн бус зардлын дүн		**147,355,234.58**	**129,909,924.68**
Цэвэр хүүгийн бус орлого/зардлын дүн		**-143,909,111.27**	**-129,909,924.68**
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал		**139,261,079.59**	**154,044,354.97**
Зээлийн эрсдэлийн зардал		8,699,522.19	1,383,307.17
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал		**130,561,557.40**	**152,661,047.80**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		-	0.14
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		1,840,352.00	6,809,135.00
Үйл ажиллагааны ашиг/алдагдал		**128,721,205.40**	**145,851,912.94**
Татварын төлөхийн өмнөх ашиг		128,721,205.40	145,851,912.94
Орлогын татварын зардал	18	1,391,795.85	1,480,268.13
Тайлант үеийн ашиг		**127,329,409.55**	**144,371,644.81**

Энэхүү санхүүгийн тайлангийн тодруулгууд нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.